

I маягт

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн
хуралдааны 2025 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тогтоолын ... дүгээр
хавсралт

Дүүргийн Эрүү Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхэд
/Огноо/ /Газар/

НЭХЭМЖЛЭЛ

/Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа- I маягт/

I. ЗОХИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Нэхэмжлэгч:

Иргэний овог нэр/Хуулийн этгээдийн нэр, зохион байгуулалтын хэлбэр: Худалдаа
Хөгжлийн Банк ХК

Оршин суух/байх хаяг: Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн
чөлөө, 19 тоот

Иргэний бүртгэлийн дугаар:.....

Хуулийн этгээд бол регистрийн дугаар: 263553x

Цахим шуудангийн хаяг: chinzoo_b@tdbm.mn

Утасны дугаар: 8001165x

/хэд хэдэн нэхэмжлэгчтэй бол нэхэмжлэгч тус бүрээр дээрх мэдээллийг өгч хавсаргана уу/

Хариуцагч:

Иргэний овог нэр/Хуулийн этгээдийн нэр, зохион байгуулалтын хэлбэр: Нийслэлийн
шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

Оршин суух/байх хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн
хуулийн гудамж 3, Нарны гүүрний зүүн хойно байрлалтай. 5 давхар байшин
Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

Иргэний бүртгэлийн дугаар:

Хуулийн этгээд бол регистрийн дугаар:

Цахим шуудангийн хаяг:

Утасны дугаар: 7703119x, 9955421x

/хэд хэдэн хариуцагчтай бол хариуцагч тус бүрээр дээрх мэдээллийг өгч хавсаргана уу/

II. НЭХЭМЖЛЭЛИЙН ШААРДЛАГА:

☐ Мөнгөн хөрөнгө гаргуулах /3.1, 3.2, IV, V, VI хэсгүүдэд хариулна уу/

*(Таны шаардаж байгаа мөнгөн хөрөнгө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20
дахин нэмэгдүүлснээс дээшгүй хэмжээтэй байх ёстой.)*

☐ Барьцааны зүйлээс үүргийг хангуулах /3.2, V, VI хэсгүүдэд хариулна уу/

- ☒ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгуулах /3.3, V, VI хэсгүүдэд хариулна уу/

III. МАРГААНЫ АГУУЛГА:

3.1. Хариуцагчаас мөнгөн хөрөнгө гаргуулах болсон үндэслэлийг сонгоно уу.

- ☐ Хариуцагчтай байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу шаардаж байгаа мөнгөн хөрөнгө (A-1-A-15 маягтаас тохирохыг бөглөнө үү)
- ☐ Дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээний үнэ (Б-1 маягтыг бөглөнө үү)
- ☐ Хөдөлмөрийн гэрээний дагуу олгоогүй цалин хөлс (Б-2 маягтыг бөглөнө үү)
- ☐ Эд хөрөнгө, эрүүл мэндэд учирсан гэм хор (Б-3 маягтыг бөглөнө үү)
- ☐ Ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор (Б-4 маягтыг бөглөнө үү)

3.2. Барьцааны зүйлээс үүргийг хангуулах шаардлагын талаар тодруулна уу.

- ☐ Мөнгө төлүүлэх ба барьцааны шаардлагыг хамт гаргаж байна. (A-13 маягтыг бөглөнө үү)
- ☐ Мөнгө төлөх шүүхийн шийдвэрийг өмнө нь гаргуулсан тул барьцааны шаардлагыг дангаар нь гаргаж байна. (A-13 маягтыг бөглөнө үү)
- ☐ Хариуцагч мөнгө төлөхийг зөвшөөрсөн боловч барьцааг зөвшөөрөхгүй байх тул барьцааны шаардлагыг дангаар нь гаргаж байна. (A-13 маягтыг бөглөнө үү)

3.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой дараах шаардлагыг гаргаж байна.

- ☐ Хөрөнгийг битүүмжлэх, хураах ажиллагааны талаарх шаардлага (Б-5 маягтыг бөглөнө үү)
- ☐ Хөрөнгийн үнэлгээ тогтоох ажиллагааны талаарх шаардлага (Б-6 маягтыг бөглөнө үү)
- ☒ Хөрөнгийг дуудлага худалдаанд оруулах ажиллагааны талаарх шаардлага (Б-7 маягтыг бөглөнө үү)

IV. ГЭРЭЭНИЙ МАРГААН: Мөнгөн хөрөнгө гаргуулах болон барьцааны үүргийг шаардах үндэслэл болсон гэрээ нь

- ☐ Худалдах-худалдан авах гэрээ (A-1 маягтыг бөглөнө үү)
- ☐ Зээлийн гэрээ (A-2 маягтыг бөглөнө үү)
- ☐ Банк ба банк бус санхүүгийн байгууллагын зээлийн гэрээ (A-3 маягтыг бөглөнө үү)
- ☐ Бэлэглэлийн гэрээ (A-4 маягтыг бөглөнө үү)

- | | |
|---|---------------------------|
| ☐ Эд хөрөнгө хөлслөх гэрээ | (А-5 маягтыг бөглөнө үү) |
| ☐ Түрээсийн гэрээ | (А-6 маягтыг бөглөнө үү) |
| ☐ Санхүүгийн түрээсийн гэрээ | (А-7 маягтыг бөглөнө үү) |
| ☐ Ажил гүйцэтгэх гэрээ | (А-8 маягтыг бөглөнө үү) |
| ☐ Даатгалын гэрээ | (А-9 маягтыг бөглөнө үү) |
| ☐ Мөнгөн хадгаламжийн гэрээ | (А-10 маягтыг бөглөнө үү) |
| ☐ Зуучлалын гэрээ | (А-11 маягтыг бөглөнө үү) |
| ☐ Тээвэрлэлтийн гэрээ | (А-12 маягтыг бөглөнө үү) |
| ☐ Барьцааны гэрээ | (А-13 маягтыг бөглөнө үү) |
| ☐ Хамтран ажиллах гэрээ | (А-14 маягтыг бөглөнө үү) |
| ☐ Бусад гэрээ | (А-15 маягтыг бөглөнө үү) |

V. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тодруулах асуулт:

5.1. Та хариуцагчийн оршин суугаа хаягийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж байна уу?

- ☒ Тийм
☐ Үгүй

5.2. Нэхэмжлэлд дурдсан үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр байгаа юу?

- ☒ Тийм
☐ Үгүй

5.3. Маргаж байгаа зүйл болон түүний үндэслэлийн талаарх өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа, эсхүл эрүүгийн журмаар шалгаж байгаа юу?

- ☐ Тийм
☒ Үгүй

5.4. Та хариуцагчтай эвлэрэн хэлэлцэх хүсэлтэй юу?

- ☐ Тийм
☒ Үгүй

5.5. Маргааныг эвлэрүүлэн зуучлал, эсхүл арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцсон уу?

- ☐ Тийм
☒ Үгүй

5.6. Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмаар хуульд заасан байгууллагад хандсан уу?

- ☐ Тийм
☒ Үгүй

VI. Нэхэмжлэлд хавсаргасан баримтын жагсаалтыг хавсаргана уу.

1. Сухбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн №181 /ШШ2023/030х тоот шийдвэр - 11 хуудас,

2. 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн №210/МА2024/0185х тоот магадлал - 10 хуудас,
 3. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчийн №191/1111112025/0087х дугаар захирамж-4 хуудас,
 4. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчийн №191/ШШ2025/0001х дугаар захирамж - 4 хуудас,
 5. “Сайн майнинг” ХХК болон Худалдаа, хөгжлийн банк ХК нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр №tdbm/405х/2024 тоот “Эвлэрлийн гэрээ” - 2 хуудас,
 6. “Их наран энерги” ХХК болон Худалдаа, хөгжлийн банк ХК нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр №tdbm/406х/2024 тоот “Эвлэрлийн гэрээ” - 2 хуудас,
 7. “Сайн майнинг” ХХК болон Худалдаа, хөгжлийн банк ХК нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр №tdbm/407х/2024 тоот “Зээлийн өр төлбөрт хөрөнгө тооцон өгөх гэрээ” - 1 хуудас,
 8. “Их наран энерги” ХХК болон Худалдаа, хөгжлийн банк ХК нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр №tdbm/408х/2024 тоот “Зээлийн өр төлбөрт хөрөнгө тооцон өгөх гэрээ” - 1 хуудас,
 9. Хүлээлцэх акт - 5 хуудас,
 10. Худалдаа хөгжлийн банкны 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн №5/2360 дугаар хүсэлт - 1 хуудас,
 11. Худалдаа, хөгжлийн банкны хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар - 1 хуудас,
 12. Итгэмжлэл- 2 хуудас,
 13. Төлбөрийн даалгавар- 1 хуудас,
 14. Төлбөр төлсөн баримт- 1 хуудас
- Хавсралт нийт 46 хуудастай.

ГАРЫН ҮСЭГ:

**Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны
тойргийн шүүхэд**

/Огноо/

/Газар/

**ХӨРӨНГИЙГ ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ
ШААРДЛАГА**

/Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа- Б-7 маягт/

1. Нэхэмжлэлийн шаардлага:

- ☒ Хөдлөх эд хөрөнгийг үнэ хаялцуулах дуудлага худалдаа явуулахтай холбоотой ажиллагааг хүчингүй болгуулах
- ☐ Үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, эдийн бус хөрөнгө, түүх, соёлын өвд хамаарах үнэт зүйл, тусгай зөвшөөрлийг албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулахтай холбоотой ажиллагааг хүчингүй болгуулах
- ☐ Бусад

2. Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл:

- ☒ Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журам зөрчсөн,
- ☐ Иргэний хуульд заасан журам зөрчсөн,
- ☐ Бусад

3. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах үндэслэл болсон шийдвэр

3.1. Анхан шатны шүүхийн шийдвэрийн огноо, дугаар:

.....

3.2. Давж заалдах шатны шүүхийн магадлалын огноо, дугаар:

.....

3.3. Хяналтын шатны шүүхийн тогтоолын огноо, дугаар:

.....

4. Та шийдвэр гүйцэтгэх ажиллагааны аль оролцогч вэ?

- ☐ Төлбөр авагч
- ☐ Төлбөр төлөгч
- ☒ Гуравдагч этгээд /өмчлөгч/
- ☐ Дуудлага худалдааны оролцогч

5. Эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргасан байдал

- ☐ Ахлах шийдвэр гүйцэтгэгч
- ☐ Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч

6. Эрх бүхий албан тушаалтнаас хариу авсан уу?

- ☐ Тийм
- ☐ Үгүй /7-д хариулах шаардлагагүй/

7. Эрх бүхий албан тушаалтанаас хариу авсан огноо:.....

8. Та аль дуудлага худалдаа явуулах ажиллагаанд гомдол гаргаж байна вэ?

- ☒ Анхны дуудлага худалдаа
☐ Хоёр дахь дуудлага худалдаа

9. Та өөрийн хөрөнгөө бие даан худалдан борлуулах санал гаргаж байсан уу?

- ☐ Тийм
☐ Үгүй

10. Эд хөрөнгө, эрхийг /анхны, хоёр дахь/ албадан дуудлага худалдаанд оруулах ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолын огноо, дугаар:

.....

11. Шийдвэр гүйцэтгэгч нь дуудлага худалдаа явуулах тухай ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолыг мэдэгдсэн эсэх

- ☐ Тийм
☒ Үгүй /12-т хариулах шаардлагагүй/

12. Албадан дуудлага худалдааны мэдэгдлийг хүлээн авсан огноо:

.....

13. Тийм, Үгүй гэсэн хариултын аль нэгийг сонгоно уу?

13.1. Албадан дуудлага худалдааг нийтэд мэдээлсэн үү?

- ☒ Тийм
☐ Үгүй

13.2. Албадан дуудлага худалдаа зохион байгуулагдсан уу?

- ☐ Тийм
☒ Үгүй /13.3-т хариулах шаардлагагүй/

13.3. Үл хөдлөх эд хөрөнгө болон эрх дуудлага худалдаагаар борлогдсон уу?

- ☐ Тийм /13.5-д хариулах шаардлагагүй/
☒ Үгүй /13.4-т хариулах шаардлагагүй/

13.4. Дуудлага худалдаагаар борлогдсон хөрөнгийн өмчлөх эрх ялагч буюу худалдан авагчийн өмчлөлд шилжсэн үү?

- ☐ Тийм
☒ Үгүй

13.5. Дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт суутган авахыг төлбөр авагчид санал болгосон уу?

- ☐ Тийм
☒ Үгүй

13.6. Та дуудлага худалдаатай холбоотой ажиллагаанд шүүхэд гомдол гаргах хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн үү?

- ☐ Тийм /үндэслэл, шалтгаанаа 14-т тайлбарлана уу/
☒ Үгүй

14. Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл, үйл баримтын талаар ач холбогдолтой гэж үзсэн нөхцөл байдлын талаар 300 үгэнд багтаан бичнэ үү.

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 05- ны өдрийн №181/ШШ2023/03099х тоот шийдвэр, 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн №210/МА2024/01852х тоот магадлалаар Говийн наран ХХК-иас (РД:509554х) зээлийн гэрээний төлбөрт (.....) төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн (.....) төгрөг, нийт (.....) төгрөгийг гаргуулан Худалдаа хөгжлийн

банканд олгохоор шийдвэрлэсэн. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад Говь-Алтай аймгийн Бугат сумын нутагт байрлах Бургастайн хилийн боомтын гаалийн хяналтын талбайд овоолсон Говийннаран ХХК-ийн төмрийн хүдрийн баяжмалын овоолгыг Худалдаа, хөгжлийн банкны өмчлөлд шилжүүлэхээр тохиролцож 2024 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн №tdbm/409х/2024 тоот “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эвлэрч зээлийн өр төлбөрт хөрөнгө тооцон авах гэрээ”-г байгуулсан. Гэтэл, 2025 оны 02 дугаар сарын 21-ны өдөр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас зохион байгуулахаар зарласан хөдлөх эд хөрөнгийн үнэ хаялцуулах албадан дуудлага худалдааны зар олон нийтэд нийтлэгдсэн байна. Тодруулбал, хөдлөх эд хөрөнгийн үнэ хаялцуулах албадан дуудлага худалдааны зарын 1 дүгээрт Говь-Алтай аймгийн Бургастайн боомтын гаалийн хяналтын бүсэд байрлах 63,01 хувийн агууламжтай тонн төмрийн хүдрийн баяжмал орсон байна. 2024 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн №tdbm/409х/2024 тоот “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эвлэрч зээлийн өр төлбөрт хөрөнгө тооцон авах гэрээ” -ний дагуу 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр №2536000х/03 дугаар “Эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлсэн тухай тэмдэглэл” -ийг үйлдэж Говь-Алтай аймгийн Бугат сумын нутагт байрлах Бургастайн хилийн боомтын гаалийн хяналтын талбайд овоолсон Говийннаран ХХК-ийн тонн төмрийн хүдрийн баяжмалыг талууд хүлээлцэж, Худалдаа хөгжлийн банкны зүгээс 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн №5/2360 дугаар хүсэлтээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгах хүсэлтийг Банкны төлбөр барагдуулах газарт хүргүүлсэн. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талууд эвлэрсэн төлбөр төлөгч Говийннаран ХХК-ийн зүгээс өр төлбөрт тооцон дээрх хөрөнгийг Худалдаа, хөгжлийн банкны өмчлөлд шилжүүлсэн, Говь-Алтай аймгийн Бугат сумын нутагт байрлах Бургастайн хилийн боомтын гаалийн хяналтын талбайд Худалдаа, хөгжлийн банкны өмчлөлийн хөрөнгөөс өөр ямар нэг хөрөнгө дээрх хаягт байрлах талбайд байхгүй, 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд алданги болон өр төлбөртөө тооцон шилжүүлсэн. Мөн, “Сайн майнинг” ХХК болон Худалдаа, хөгжлийн банк ХК нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр №tdbm/407х/2024 тоот “Зээлийн өр төлбөрт хөрөнгө тооцон өгөх гэрээ”. “Их наран энерги” ХХК болон Худалдаа, хөгжлийн банк ХК нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр №tdbm/408х/2024 тоот “Зээлийн өр төлбөрт хөрөнгө тооцон өгөх гэрээ”-нүүдийг байгуулж 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр “Сайн майнинг” ХХК-ийн зээлийн өр төлбөрт тооцож тн төмрийн хүдрийн баяжмал, “Их наран энерги” ХХК-ийн зээлийн өр төлбөрт тооцож тн төмрийн хүдрийн баяжмалыг акт, протокол үйлдэн Худалдаа, хөгжлийн банканд хүлээлгэн өгсөн. Иймд, 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас зохион байгуулахаар зарласан хөдлөх эд хөрөнгийн үнэ хаялцуулах албадан дуудлага худалдааны тогтоол, холбогдон хийгдсэн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хүчингүй болгож өгнө үү.

15. Хавсаргасан баримтыг жагсаана уу.

НЭХЭМЖЛЭЛ ГАРГАСАН: